



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 дугаар сарын 26 өдөр

Дугаар 12

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын XII хурлыг 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 31 гишүүд оролцохоос 31 гишүүнтэй 100 % ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Баянхошуу хилийн боомтод ариутгалын пункт барьж байгуулах ажлын талаарх мэдээлэл сонсох,
2. Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар тогтоолын дагуу хот, аймаг, сум хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалтыг сунгах талаар хэлэлцэх,
3. ОХУ-тай харилцах боомтууд дахь хөдөлгөөний талаарх мэдээлэл сонсох,
4. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, аймгийн Онцгой комиссын шийдвэрийг зөрчсөн, худал мэдээлэл өгсөн, тараасан, асуумжийг худал өгсөн иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцсон талаарх мэдээлэл сонсов,
5. Чойбалсан хотын хог хаягдал, шар усны үер, Ивээл хорооллын ариутгал, халдваргүйтгэлийн талаарх мэдээллийг сонсов,
6. Байгууллага, хамт олны шинэлгээ хийхгүй байхад хяналт тавих талаар аймгийн Онцгой комиссын гишүүд, байгууллагын удирдлагуудад чиглэл өгөх,
7. Төрийн байгууллагуудын албан хаагч нарт ажлаас чөлөө олгох хүсэлтийг шийдвэрлэх,
8. Сүм хийдээр иргэдийг үйлчлүүлэхгүй байх, согтууруулах ундаагаар үйлчилгээ үзүүлж буй газруудыг түр хаах эсэхийг хэлэлцэх,
9. Төрийн албан хаагчдыг албан томилолтоор гадаад улсад зорчихыг түр хугацаагаар хориглох,
10. Гол, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах,

11. Чойбалсан хот доторх нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох,

12. Аймгийн Онцгой комиссоос иргэдэд цаг үеийн холбогдолтой мэдээлэл хүргэх "Мэдээний цаг"-ийг тогтоохыг тус тус хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, Д.Мөнхтуяа, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

Ч.Оюунаа нарт

1. Баянхошуу хилийн боомтод ариутгал, халдваргүйтгэлийн пунктыг Олон улсын стандартын дагуу барьж байгуулах үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг аймгийн Онцгой комисст танилцуулж, шийдвэр гаргуулахыг,

2. Ульхан, Эрэнцав хилийн боомтын тусгаарлах байр, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг шалгах, заавар зөвлөмж өгөх ажлын хэсгийг томилон ажиллуулахыг,

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр, сумдын Засаг дарга нарт:

1. Хот, аймаг, сум хоорондын зорчигч тээвэр, хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас 3 дугаар сарын 3-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгаж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авахыг,

Бүсийн төв-аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад

1. Хүндэтгэн үзэх шалтгаантай /ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, албан томилолт, ажлын зайлшгүй шаардлага гэх мэт/ хот, аймаг, сум хооронд зорчих төрийн албан хаагч болон иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр нэвтрэх зөвшөөрөл олгохыг,

2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сүм, хийдэд Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр албан шаардлага хүргүүлж ажиллахыг,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн

П.Бат-Өлзийд

1. Холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн ОХУ-тай харилцах Ульхан хилийн боомтын үйл ажиллагааг түр хугацаагаар хаах саналыг боловсруулж хүргүүлэхийг,

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын дарга нарт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийг зөрчсөн, худал мэдээлэл өгсөн, тараасан, асуумжийг худал өгсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд тухай бүр хуулийн хариуцлага тооцож ажиллахыг,

Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очир, "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын дарга Б.Тэгшжаргал нарт:

1. Хэрлэн сумын хэмжээнд болон "Ивээл" хорооллын хог хаягдал, ариутгал, халдваргүйтгэлийг хийх хөрөнгийг шийдвэрлүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг,

Агентлаг, аж ахуйн нэгж, байгууллага, сумдын Засаг дарга нарт:

1. Байгууллага, хамт олноороо шинэлгээ хийхгүй байхад хяналт тавих,
2. Хот, хөдөө зорчиж яваад хөдөлгөөний хязгаарлалтанд орсон ажилтан, албан хаагчдад 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 3-ны өдрийг хүртэл цалинтай чөлөө олгохыг,
3. Төрийн албан хаагчдыг гадаад орон руу албан томилолтоор зорчихыг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд зогсоох арга хэмжээ авахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, сумдын Засаг дарга нарт:

1. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх ресторан, кафены ажиллах цагийн хуваарийг 06:00-20:00 цаг хүртэл, худалдаалах хүнсний дэлгүүр, минимаркет, супермаркет, хайпермаркет, хүнсний бөөний төвийн ажиллах хугацааг 06:00-22:00 цаг хүртэл ажиллахаар тогтоосон цагийн хязгаарын дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавих,

2. Шинэ коронавирусийн халдвар "Covid-19" хөрш орнуудад дэгдсэнтэй холбогдуулан халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх баар, караокены үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл түр хугацаанд зогсоох шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах,

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, сумдын Засаг дарга нарт:

1. Иргэд, тээврийн хэрэгслийг гол, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байхыг анхааруулах, аймгийн Онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөрд:

1. Чойбалсан хот доторх нийтийн тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийг хүртэл хугацаанд түр зогсоохыг,

Аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албаны дарга нарт:


1. Долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагийн 14:00 цагт аймгийн Онцгой комиссын шийдвэр, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж байхыг,


Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Хэрлэн сумын Засаг даргын орлогч, О.Пүрэв-Очир нарт:

1. Хэрлэн суманд хөдөлгөөнт эргүүлийн 3 цэгийг нэмэлтээр байгуулах, эргүүл гаргах хуваарь, шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэхийг,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Эрдэнэбаяр, Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа Б.Бямбаа нарт:

1. Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутаг дэвсгэрт 20 гаруй зээр тодорхойгүй шалтгааны улмаас хорогдсон байх тул тандалт, судалгаа хийх, шалтгааныг тогтоох, дээж авч шинжилгээнд явуулах, сэг зэмийг цуглуулж устгахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА